

ОРШИЛ

“Онжим” ХХК нь Горхи-Тэрэлжийн БЦГ-т хэрэгжих “Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төслийн барилга байгууламжийн барилгын ажлыг 2024 онд эхлүүлэхээр төлөвлөсөн.

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь (БОМТ) “Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төслийн барилгын ажлын үед байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, түүнд шаардагдах зардал, хяналт зэргийг багтаасан байгаль орчны дагаж мөрдөх гол бичиг баримт юм.

Тус БОМТ нь сөрөг нөлөө, эрсдлээс урьдчилан сэргийлэх, багасгах, эсвэл зайлсхийх зорилгоор барилгын ажлын өмнө, барилгын ажлын үед байгаль орчныг хамгаалах ажлуудыг үргэлжлүүлэн сайжруулахыг чармайх юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- ✓ Байгаль орчинд халгүй үйл ажиллагаа явуулах бүхий л боломжийг мэргэжлийн зөвлөлтэй хамтран төлөвлөх
- ✓ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд барилгын ажлын үед байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах бодит арга хэмжээг төлөвлөж, түүнийг хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааг тодорхойлох
- ✓ Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах тал дээр анхаарч ажиллах, энэ талаар бүх ажилчдад сургалт явуулах зэрэг болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2019 оны 10-р сарын 29-ны өдөр БОАЖЯ-ны сайдын баталсан А/618 тоот "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-д нийцүүлэн боловсруулсан болно.

“Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төслийн барилга байгууламжийн барилгын ажлын үеийн БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт 6.710.000 (Зургаан сая долоон зуун арван мянга) төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

БОМТ нь нийт 12 бүлэг, төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийг бууруулах арга зам, зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хавсралт зэргийг агуулсан болно.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

ТӨСЛИЙН НЭР: “Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төсөл

ТӨСЛИЙН ЗОРИЛГО: Уг төсөл нь шаардлага хангасан эх хүүхдийн сувилал, амралтын газар бүхий соёл амралтын хүрээлэн байгуулах замаар иргэдийн аз жаргалтайгаар амрах, ажиллах боломжийг нэмэгдүүлэх зорилготой.

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН БАЙРШИЛ:

“Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төсөл хэрэгжих талбай нь засаг захиргааны хуваарилалтаар Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт, Горхи-Тэрэлжийн БЦГ-т байрлана. Талбайн хэмжээ 8.9 га.

Тус амралтын газар нь Улаанбаатар хотоос зүүн хойш 60.6 км зайд, Тэрэлжийн гүүрнээс 4.0 км, Налайх дүүргийн төвөөс 15.2 км зайд байрладаг.

Төслийн талбайн газарзүйн солбилцлууд

№	Цэгийн дугаар	N	E
1	1	47° 48' 44.997"	107° 23' 17.116"
2	2	47° 48' 36.874"	107° 23' 15.938"
3	3	47° 48' 37.417"	107° 22' 50.700"
4	4	47° 48' 40.742"	107° 22' 48.155"



Зураг 1. Төслийн талбайн байршил (Google earth)

ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТӨЛӨВЛӨЛТ

“Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төсөл нь 30 ажилтантай жилийн 4 улиралд үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөсөн бөгөөд нэг ээлжиндээ 180 амрагчдыг хүлээн авах хүчин чадалтай байна.

Төслийн бүтээн байгуулалтын ажлыг 2024 онд эхлүүлж 2025 онд дуусган үйл ажиллагаагаа эхлүүлэхээр төлөвлөсөн байна.

ДЭД БҮТЭЦ

Цахилгаан эрчим хүч: Төсөл хэрэгжүүлэгч нь цахилгаан эрчим хүчний хэрэглээгээ цахилгааны нэгдсэн сүлжээ буюу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн өндөр хүчдэлийн шугамаас 400кВа трансформатор байгуулан аялал жуулчлалын цогцолборт шаардагдах газрууд руу далд холболтоор хүргэснээр өдөр тутмын цахилгаанаар хангахаар төлөвлөсөн байна. (Техникийн нөхцөл. Дугаар:15/05251/21)

Усан хангамж: “Онжим” ХХК нь барилгын ажлын үеийн болон амрагчид, ажилчдын унд ахуйн ус хэрэглээг хангахаар эзэмшил талбайд 1 ширхэг гүний худгийг мэргэжлийн байгууллагаар гаргуулж холбогдох бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

Дулаан хангамж: “Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төсөл нь жилийн 4 улирлын турш үйл ажиллагаагаа явуулах тул хүйтний улиралд барилга байгууламжийн дулааныг халаалтын зүүх, цахилгаан хосолсон хэлбэрээр халаахаар төлөвлөсөн байна.

Харилцаа холбоо: Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь үүрэн телефоны бүхий л сүлжээ ашиглах боломжтой бөгөөд үйл ажиллагаандаа дотоод сүлжээгээр барилгын автомат хяналтын систем, дохиолол хамгаалалтын системийг ашиглана. Аялал жуулчлалын цогцолборын агааржуулалт, кабелийн телевиз зэргийг хамруулж иж бүрэн автомат сүлжээ бий болгоно. Мөн аялал жуулчны цогцолборын удирдлагын системд зориулан ажиллагсадтайгаа холбогдох явуулын станцыг суурилуулна.

Зам харилцаа: Төсөл хэрэгжих талбай нь Горхи-Тэрэлжийн хатуу хүчилттай авто замаас урагш 1.3 км-ийн зайтай байдаг. Төсөл хэрэгжих хугацаанд шороон замыг сайжруулах, тэмдэг тэмдэглээг тавих арга хэмжээг хэрэгжүүлэх юм.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

УУР АМЬСГАЛ

Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газар нь эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд хаврын улирлын дулааралт, намрын улирлын сэрүүслийн явц ижилхэн зун сэрүүн чийглэг, өвөл нь хүйтэн чийглэг зэрэг уур амьсгалын үндсэн үзүүлэлттэй юм. Тус бүс нутаг нь Монгол орны бусад нутгаас хамгийн их хур тунадастай, чийглэг, сэрүүн, өвөл нь цасархаг харьцангуй дулаавтар, тунгалаг цэнгэг агаартай зэрэг олон давуу талуудтай.

Хэнтийн уулархаг нутагт агаарын дундаж температур хүйтний улиралд буюу 1-р сард голын сав хөндийгөөр -21°C -аас -23°C , уул нуруундаа -20°C -аас 21°C байдаг. Дулааны улирал болох 7-р сард агаарын дундаж температур уул нуруундаа 14°C , голын хөндийд 38°C байдаг. Харин Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар орчмоор 7-р сарын агаарын дундаж температур 16°C -аас 37.8°C , 1-р сарын агаарын дундаж температур -21°C -аас -27.4°C байна.

Горхи-Тэрэлж орчмоор нарны гийгүүлэлт жилдээ 2650-2800 цаг үргэлжилдэг.

Хур тунадасны хэмжээ жилээс жилд хэлбэлзэл ихтэй байдаг бөгөөд хур тунадасны олон жилийн явцаас харахад тухайн нутгийн хувьд тунадас ихтэй жилдээ Тэрэлж орчмоор 450-500 мм тунадас ордог байхад тунадас бага жилдээ 260-280 мм тунадас ордог байна.

Хан хэнтийн нуруу, Түүл голын сав газрын салхи нь хойд, баруун хойноос ноёлох чиглэлтэй. Салхины жилийн дундаж хурд 0.9-2.3 м/сек, дундаж их хурд 5 сард 1.2-4.0 м/сек, хамгийн намуун үедээ 12-1 сард 0.7-1.4 м/сек дундажтай ба хойт зүгийн салхи зонхилж, өмнө зүгийн салхи нилээд ажиглагддаг байна.

Агаарын даралт дунджаар 843 гПа (630) мм, голын хөндий нутгуудад 865 гПа (650 мм) хүртэл хэлбэлздэг. Агаарын даралт жилийн турш тогтвортой өөрчлөлт багатай 10, 11 сард 845-870 гПа, зун 7 сард 840 гПа орчим болдог.

АГААРЫН ЧАНАР

Төслийн талбай нь Налайх дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэсвэрт байрлах ба талбай орчим агаар бохирдуулах томоохон суурин эх үүсвэр байхгүй, гол бохирдуулах эх үүсвэр нь элэгдэл эвдрэлд өртсөн талбайн тоосжилт юм. Агаарын чанарын шинжилгээний дүнгээр “Хэвийн” болон “Бага бохирдолтой” түвшинд буюу агаарын түгээмэл бохирдуулах бодисын хүлцэх агууламж (MNS4585:2016) стандартын хэмжээнд байна.

ГЕОЛОГИЙН ТОГТОЦ, ГЕОМОРФОЛОГИ,

Геологийн тогтоц: Хэнтий нуруу нь геологийн тогтоцын хувьд нэлээд өвөрмөц дүр төрхтэй. Хэнтий нуруунд эрт төрмөлийн чулуун нүүрсний галавын нүүрст ба нүүрстөрөгчит шаварлаг занар, наангжин, зануужин, Түүл, Заан голуудын эхэн сав газраар, девоны ангилагдаагүй чулуулаг, цахиурлаг занар, хас, нүүрст ба нүүрстөрөгчид шаварлаг занар зэрэг чулуулаг Өвөр минж, Туулын эх, Тэрэлжийн сав газраар тархсан. Төслийн талбай нь геологийн тогтоцын хувьд интрузив гранотойд зонхилсон байна.

Геоморфологи: Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар нь хотгор гүдгэрийн хувьд дундаж өндөртэй уулархаг болон голын хөндий, хотос, хонхрууд зонхилно. Төслийн талбайн өмнөд хэсэг нь Туул голын хөндий бүхий цав толгод ухааа гүвээт тал, талбайн хойд хэсгээр Бага Хэнтийн нурууны салбар уулс тархсан ба Газрын гадаргын өндөр нь 1410 м байна. Төслийн талбай нь геоморфологийн хувьд Голын хурдаст тал хэв шинжид хамрагдана.

ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УС

Гадаргын ус: Тус төслийн талбай нь Туул голын ай савд багтах бөгөөд төсөл хэрэгжих талбайтай хамгийн ойр орших гол нь 70 орчим метрийн зайд урсах Туул голын татам юм. Тус татмаар үер, устай жилд ус урсдаг бөгөөд хур тунадас багатай, хуурайшилттай жилүүдэд хуурай сайр хэлбэрээр байна. Харин төслийн талбайгаас 300 гаруй метрийн зайд Туул голын томоохон салаа урсана.

Газрын доорх ус: Туул голын сав газрын хэмжээнд нүх сүвийн, ан цавын гэсэн үндсэн 2 төрлийн ус агуулагч бүрдэл тархсан ба ан цав, нүх сүвийн ус болох рашаан тархсан байна. нүх сүвэрхэг бүрдэл нь доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас дотор, ан цавлаг бүс нь кембри, девон, карбоны тунамал, эсвэл юра, триасын түрмэл чулуулаг дотор тус тус бүрэлддэг.

ХӨРСӨН БҮРХЭВЧ

Төсөл хэрэгжих Горхи-Тэрэлжийн БЦГ нь хөрс газарзүйн мужлалаар хөрс био-уур амьсгалын өндрийн бүсчлэл бүхий Хангай-Хэнтийн мужийн умардын 43-р тойрогт хамрагдана. Төслийн талбай нь Туул голын ай савд хамаарах бөгөөд газрын ерөнхий төрх хойноос урагш чиглэлд бага зэргийн налуу, ургамлан нөмрөг 80%, газрын гадарга нугархаг, хөрсний механик бүрэлдэхүүн нь ялмагт, чийглэг, үндэслэг бүтэцтэй байна.

УРГАМЛАН НӨМРӨГ

Горхи-Тэрэлжийн БЦГ-ын нутаг дэвсгэр нь ургамал газарзүйн мужлалаар Евразийн шилмүүст ойн мужийн Өвөр байгалийн уулын тайгын хошууны Төв Хэнтийн уулын тайгын тойрог, Евразийн хээрийн мужийн Өмнөд Хэнтийн уулын хээрийн тойрогт тус тус хамаарагдана (Юнатов, 1950).

Төслийн 8.9 га талбайд нийт 18 зүйлийн ургамал ургаснаас ширгэ улалж, навтгар таван салаа, лений ботууль голчлон тархсан байна. Уг газрын ургамал нөмрөг нь бургаст сорвоот ба улалжит намаг, алаг өвст нуга болон хялганат, буур өвст, биелэг өвст хэв шинж хосолсон хэв шинжтэй байна.

АМЬТНЫ АЙМАГ

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар нь Бага Хэнтийн нурууны Өмнөд салбар уулс, Ар өвөр Горхи, Заан-Тэрэлж голын сав, Туул голын эх орчмын нутаг орох бөгөөд Монгол орны амьтны газарзүйн мужлалаар Хэнтийн тойрогт багтах бөгөөд /Банников, 1954/ ойт хээр, хээр, голын дагуух шугуйд амьтны аймгийн зүйлийн олон янз байдал болон амьдрах орчны хувьд нэлээд өвөрмөц баялаг бүс нутаг юм. Түүнчлэн энэ бүс нутагт ус намгархаг орчныг шүтэн амьдрах амьтад тархсан байдаг онцлогтой юм.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ, ТҮҮХ СОЁЛЫН ӨВ

Тусгай хамгаалалттай газар нутаг: Горхи-Тэрэлжийн БЦГ нь Төв аймгийн Эрдэнэ сум, Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт нийт 293168.0 га талбайг эзлэн оршдог. Тус цогцолбор газрын нутаг дэвсгэрт Хэнтийн нурууны зүүн өмнөд хэсэг, Хэнтийн тайгын өмнөд хэсгийн ойт хээр бүхий дундаж өндөр уулс хамрагдана. Төслийн талбай нь Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хязгаарлалтын бүсэд харьяалагдана.

Төслийн талбайн 8.9 га газрын тодорхой талбай нь “Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 50 дугаар тогтоолоор баталсан Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд хамаарагдаж байна.

Тус талбайн 0.58 га нь энгийн хамгаалалтын бүсээс гадагш, 8.32 га нь энгийн хамгаалалтын бүстэй давхцалтай байна.

Түүх соёлын өв: Налайх дүүргийн нийт газар нутгийн 40 гаруй хувь нь буюу 28 мянган га газар бүхэлдээ аялал жуулчлалын бүс болоод байгаа ба тус бүс нутаг нв улсын ТХГН-т харьяалагддаг. Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь түүх соёлын дурсгалыг хадгалсан, байгалийн үзэсгэлэнт газруудтай. Тухайлбал Гүнжийн сүм, Чингис уул, Гялалзахын энгэр, Алтан өлгийн эртний мөстлөгийн хунх, Зуун ламын агуй, Мөнгөн цохио (Мэлхий хад), Лам хад зэрэг түүх соёлын дурсгал, байгалийн өвөрмөц тогтоц бүхий газруудтай.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Барилга байгууламжийн барилгын ажлын үед нийгэм, эдийн засаг, нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг БОМТ-нд тусгасан болно. "Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ"-г төлөвлөхдөө ажлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээнүүдийг төлөвлөв.

Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь барилгын ажлын явцад үүсэхээр байна. "Эдгээр нөлөө нь ажлын талбайн хэмжээнд хязгаарлагдахаас гадна түр хугацаатай бөгөөд хүрээлэн байгаа орчны эх үүсвэрт заналхийлэх, сулруулах хэмжээтэй биш" хэмээн дүгнэж байна.

Барилга байгууламжийн барилгын ажилтай холбоотой гол сөрөг нөлөөллийн үнэлгээг БОНХС-ын 2014 оны 04 сарын 10- ны өдрийн А/117 тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан аргачлалын дагуу болон нөлөөллийн оноот үнэлгээний аргыг хоёр янзаар тооцсон. Үүнд: Хөрс хуулалт, газар ухах, буцаан булах, шугам хоолой тавих үйл ажиллагаа тус бүрээс үзүүлэх нөлөөлөл болон байгалийн бүрэлдэхүүн бүрт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг тус тусад нь авч үзэн судалсан. Шинээр хийгдэх газар шорооны ажлын үед буюу барилгын суурь тавих, хөрс хуулалт, газар ухах ажлын үед барилгын материал, техник, тоног төхөөрөмж зэргийг ажлын талбай дээр авчрах, бетоны хольц, хог хаягдлыг тээвэрлэх, ачих буулгах, машин техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах, хөдөлгөх үед ажлын талбайн хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг доройтох, ил задгай барилгын хог хаягдлаар бохирдох, тоос, дуу чимээний бохирдол ихсэх зэрэг түр зуурын нөлөөллүүд үүснэ.

Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрт үзүүлж болзошгүй нөлөөлөл

№	Үзүүлэлт	Нөлөөллийн түвшин	Тайлбар
1	Газрын хэвлийн рельеф	Их	Ажлын үед шинээр газар ухах ажил хийгдэх тул энэ төрлийн нөлөөлөл их гэж үзлээ.
2	Цаг уур, уур амьсгал	Дунд	Цаг агаарын нөхцөл байдлаас ил барилгын ажиллагаа шууд хамааралтай байдаг бөгөөд цаг уурын таагүй байдлаас барилгын ажил зогсох, удаашрах зэргээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хугацаа уртасна. Хүчтэй салхиар ил задгай барилгын болон ажилчдын хог хаягдал хийсч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлж болзошгүй.
3	Агаарын чанар	Бага	Газар ухах, хөрс хуулах, барилгын ажил болон техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөний үйл ажиллагаанаас тоос шороо үүснэ. Барилгын талбайд ажиллах техникүүдийн түлшний шаталтаас хүлэмжийн хий ялгарна.
4	Усан орчин	Бага	Төслийн талбайн нөлөөллийн бүсэд гадаргын ус байгаа тул нөлөөлөл үзүүлнэ, гүний усны түвшинд барилгын ажил явагдахгүй учраас нөлөөлөхгүй.
5	Хөрс,	Их	Ажлын үед хөрс хуулалт, ухалтын ажил хийгдэх тул энд

	газрын гадарга		үзүүлэх нөлөөллийг “их” гэж үзсэн.
6	Ургамал	Дунд	Ургамал бүхий талбай хөрс хуулалтанд нөлөөлөлд өртөх тул энэ нөлөөллийн эрчим “дунд” байна.
7	Амьтан	Нөлөөгүй	Барилгын талбай нь аялал жуулчлалын бүс учир хүн болон техникийн хөдөлгөөн, дуу чимээ ихтэй тул мэрэгч амьтад болон бор шувууны багийн жижиг шувууд болон синантроп зүйлүүдээс бусад ерөнхийдөө дайжсан учир төслөөс амьтанд үзүүлэх шууд нөлөөлөл байхгүй.
8	Дуу чимээ, доргилт, чичиргээ	Бага	Барилга материал буулгах, ачих, тээвэрлэлт зэргээс үүсэх дуу чимээ, чичиргээ нь ажилдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.
9	Үнэр	Бага	Төслийн үйл ажиллагаанд барилгын болон ахуйн гаралтай хог хаягдал нь түр зуурын бага зэрэг нөлөөлөлтэй байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний дагуу тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм.

2012 онд шинэчлэгдсэн Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар төсөл хэрэгжүүлэгч нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үрдчилэн сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаварыг хянах, илрүүлэх зорилгоор БОМТ-г жил бүр шинэчлэн боловсруулж төрийн захиргааны байгууллагаар батлуулж хэрэгжүүлдэг.

Төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээг сайтар төлөвлөж, цаг тухайд нь хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж байх шаардлагатай байдаг.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Барилга байгууламжийн барилгын ажлын үед нийгэм, эдийн засаг, нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийг БОМТ-нд тусгасан болно. "Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ"-г төлөвлөхдөө ажлын үед байгаль орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээнүүдийг төлөвлөв. Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь барилгын ажлын явцад үүсэхээр байна. "Эдгээр нөлөө нь ажлын талбайн хэмжээнд хязгаарлагдахаас гадна түр хугацаатай бөгөөд хүрээлэн байгаа орчны эх үүсвэрт заналхийлэх, сулруулах хэмжээтэй биш хэмээн дүгнэж байна.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн өртөг (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
I. Агаарын чанар								
1	Барилгын ажлын үед тоосжилт үүсэх	... Тоосжилт ихээр үүсч болзошгүй газруудад ус шүршиж, чийгшүүлэх	Барилгын ажлын болон ойролцоох талбай	200.000	-	200.000	Барилгын ажлын үед	MNS 2000:2016
		... Барилгын ажилд бетон зуурмагийн төхөөрөмж ажиллуулах бол барилгын талбайн салхины доор байрлуулах		-	-	-		
2	Барилгын материал болон хог хаягдал тээвэрлэх үед тоосжилт үүсэх	... Орон нутгийн зам сүлжээг ашиглаж, шаардлагагүй олон салаа зам үүсгэхээс сэргийлэх	Барилгын ажлын болон ойролцоох талбай	-	-	-	Барилгын ажлын үед	ЗГ-ын 2011 оны 311-р тогтоол
		... Хог хаягдлыг битүүмжлэл сайтай тээврийн хэрэгсэлээр тээвэрлэх						
		... Сул материал (элс хайрга, ул хөрс) тээвэрлэхдээ тохирох материалаар хүчих						
3	Машин техникээс агаар бохирдуулагч хий ялгарах	... Машин техникийг үзлэгт хамруулж, засвар үйлчилгээ хийх	Барилгын ажлын талбайд	-	-	Үйл ажиллагаа-ны зардалд	Барилгын ажлын үед	MNS 4585:2016
4	Ахуйн хог хаягдлаас тааламжгүй үнэр үүсэх	... Хогийн сав, хогийн цэгийн ашиглалтанд хяналт тавих	Барилгын ажилчдын тосгонд	-	-	Үйл ажиллагаа-ны зардалд	Барилгын ажил эхлэхийн өмнө	Хог хаягдлын тухай хууль MNS 5344:2007
		... Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж 2-дочг түүхий эдийн цэгт хүргэх					Барилгын ажлын үед	
		... Хог хаягдлыг богино хугацаанд зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах						
		... Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг дулааны улиралд хийлгэх					200.000	

“Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

II. Усан орчин								
5	Хатуу, шингэн хог хаягдлаар Туул голын усанд бохирдол үүсгэж болзошгүй	... Хог хаягдлын цэгийн орчныг цэвэрлэх, ариутгах ... Хог хаягдлыг богино хугацаанд зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах	Барилгын ажлын талбайд	-	-	Үйл ажиллагаа-ны зардалд	Барилгын бэлтгэл ажлын үе шатанд	Хог хаягдлын тухай хууль (10-р зүйл)
6	Хатуу, шингэн хог хаягдлаар хөрсний усанд бохирдол үүсгэж болзошгүй	... Хог хаягдлаар дамжин хөрсний ус бохирдохоос урьдчилан сэргийлэх ... Хөрс бохирдсон тохиолдолд хөрсийг хусч аван, орчныг цэвэрлэх	Барилгын ажлын талбайд	-	-	-	Барилгын ажлын үе шатанд	MNS 5850:2008 MNS 4598:2011 MNS 4601: 2011
7	Гадаргын ба хөрсний усанд сөрөг нөлөөлөл үзүүлж буй эсэхэд хяналт тавих	... Усны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Барилгын ажлын талбай, түүний орчимд	-	-	ОХШХ-т тусгагдсан	Барилгын ажлын үе шатанд	Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм
8	Ажилчдын ундны усны аюулгүй байдал алдагдах	... Ажилчдыг эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан ундны усаар хангах	Ажилчин албан хаагчид	-	-	-	Барилгын ажлын үе шатанд	MNS 0900:2018
9	Шингэн хаягдлаар хөрсний ус бохирдож болзошгүй	... Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах шингэн хаягдлын хэмжээг аль болох бага байлгах арга хэмжээ авах	Ажилчин албан хаагчид	-	-	-	Барилгын ажлын үе шатанд	Ахуйн бохир усны цэгт тавигдах шаардлага (А/28128 тоот тушаал)

“Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

III. Хөрсөн бүрхэвч								
10	Газар шорооны ажлын үед хөрсөн бүрхэвч талхагдаж эвдрэлд өртөх	... Газар шорооны ажлаар шууд эвдрэлд өртөх талбайн шимт хөрсийг хуулж тусад нь хадгалах, нөхөн сэргээлтэнд ашиглах	Барилгын ажлын талбайд	-	-	Нөхөн сэргээлтийн зардалд	Барилгын ажлын үед	Нөхөн сэргээлтийн аргачлал MNS 5914:2008 MNS 5916:2008
11	Барилгын ажилд өртөх талбайгаас гаднах хөрсөн бүрхэвч элэгдэл эвдрэлд өртөх	... Гаднах талбайн эвдрэлийг бууруулахад анхаарч хөрсний зүй бус эвдрэлээс сэргийлэх ... Барилгын талбайд машин техник зорчих чиглэлийн тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ... Машин техник байрлуулах зогсоолд тэмдэг байрлуулах	Барилгын орчны талбайд	-	-	ХАБЭА-ны зардалд	Барилгын ажлын үед	Хөрс хамгаалах менежментийн шаардлагын дагуу
12	Машин техникийн тээвэрлэлтийн хөдөлгөөний нөлөөгөөр хөрс эвдэрч, олон салаа зам үүсэх	... Барилгын ажлын талбайд машин техник зорчих чиглэл заасан тэмдэг тэмдэглэгээ байрлуулах ... Төслийн талбайгаас гадна талбайд олон салаа зам үүсэхээс сэргийлэх	Барилгын гадна орчны талбайд	100.000	-	100.000	Барилгын ажлын үед	Хөрс хамгаалах менежментийн шаардлагын дагуу
13	Барилгын болон ахуйн хог хаягдлаар хөрс бохирдуулах	... Хогийн сав, хогийн цэгийн байдалд хяналт тавих ... Хог хаягдлыг ангилан ялгах ... Богино хугацаанд зөвшөөрөгдсөн цэгт зайлуулах ... Ахуйн хог хаягдлын цэгт дулааны улиралд ариутгал, халдваргүйжүүлэлтийг 1-2 удаа хийх	Ажилчдын тосгон, барилгын ажлын талбайд	-	-	Үйл ажиллагаа-ны зардалд	Барилгын ажлын үед	Хог хаягдлын тухай хуулийн холбогдох зүйл заалтууд

“Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

14	Машин техникийн бүрэн бус байдлаас үүдэн ШТМ-аар хөрс бохирдох	... Машин техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ШТМ асгарч гоожихоос сэргийлэх ... ШТМ асгарсан тохиолдолд тэр дор нь хусч цэвэрлэх	Барилгын ажлын талбайд	-	-	-	Барилгын ажлын үед	MNS 58505:2008 MNS 4598:2011 MNS 4601:2011
15	Карьер ашигласнаар хөрсний эвдрэлд нөлөөлөх	... Орон нутгаас түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээ байгуулах ... Гэрээний дагуу ашигт малтмал ашигласны төлбөр төлөх	-	-	-	Гэрээний дагуу	Барилгын ажлын үед	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай. Нөхөн сэргээлтийн аргачилсан заавар (А-318)
		... Карьераас материал тээвэрлэхэд гарсан хөрсний эвдрэлийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу гүйцэтгэх	Карьер түүний орчинд	-	-	Нөхөн сэргээлтийн зардалд		
16	Барилгын ажлын үед хөрсний эвдрэл үүсэх	... Барилгын талбайгаас гадна нөлөөлөлд өртөх газрыг 5.0 м-ээс хэтрүүлэхгүй байх ... Барилгын суурийн дараа техникийн нөхөн сэргээлт хийж, ургамал ургах нөхцлийг бүрдүүлэх	Барилгын ажлын талбайд	-	-	Нөхөн сэргээлтийн зардалд	Барилгын ажлын үе шатанд	Нөхөн сэргээлтийн аргачилсан заавар (А-318)

“Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

IV. Ургамал								
17	Газар шорооны ажлаар ургамлан нөмрөг устах, талхагдах	... Барилгын ажил явагдах талбайгаас өөрөөр ургамлан нөмрөгийг устгах, талхагдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, барилгын талбайг түр хашаажуулах	Барилгын ажлын талбайд	-	-	Үйл ажиллагааны зардалд	Барилгын ажлын үе шатанд	-
18	Тээвэрлэлтийн нөлөөгөөр олон салаа зам гарч ургамлан нөмрөгт нөлөөлөх	... Орон нутгийн замыг ашиглаж, шинэ зам гаргахаас сэргийлэх, жолооч нарт анхааруулга зөвлөмж өгөх	Барилгын ажлын ойролцоох талбайд	-	-	-	Барилгын ажлын үе шатанд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
19	Ургамлын зүйлийн бүрдэл хомсдол	... Орчны ургамлын зүйлийн бүрдэлд судалгаа хийх	Барилгын талбайд	500.000	-	500.000	Барилгын ажлын үе шатанд	Нүдэн баримжааны аргачлал Нөхөн сэргээлтийн аргачилсан заавар (А-318)
		... Техникийн нөхөн сэргээлт хийх	Техникийн нөхөн сэргээлт хийх талбайд	-	-	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөгөөр		
Нийт зардал						1.000.000		

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	... Гүйлс, хайлаас тарих ... Бордох, услах	Төлөвлөсөн талбайд	90	1.200.000	1.200.000	2024 онд	Мод тарих, арчлах аргачлал
2	Барилгын газар шорооны ажилд өртсөн талбайг нөхөн сэргээх	... Барилга баригдах талбайн хөрсний шимт хэсгийг хуулж тусад нь хадгалан, нөхөн сэргээлтэд ашиглах	Барилгын ажлын талбайд	-	-	Үйл ажиллагаа -ны зардалд	Барилгын ажлын үе шатанд	MNS 5916:2008
		... Барилгын ажил дууссан газарт техникийн нөхөн сэргээлт хийх		-	2.000.000	2.000.000		Нөхөн сэргээлтийн аргачилсан заавар (А-318)
		Нийт зардал				3.200.000		

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Газар шорооны ажлын үед газрын хөрсөн доороос мэдэгдээгүй түүх соёлын өв илэрч болзошгүй	... Газар шорооны ажлыг зогсоож холбогдох байгууллагад мэдэгдэх	Барилгын ажлын талбайд	-	-	-	Барилгын газар шорооны ажлын үед	Соёлын өвийг хамгаалах тухай хууль (38.3)
2	Байгалийн цогцолбор газар	... Ажилчдад тусгай хамгаалалттай газарт мөрдөх хууль тогтоомж, дүрэм журам танилцуулах	Барилгын ажлын талбайд	-	100.000	100.000	Барилгын ажлын бэлтгэл үе шатанд	Хууль тогтоомж
	Нийт зардал		-	-	-	100.000	-	-

НАЙМ. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Барилгын ажлын гүйцэтгэгч нутгийн ард иргэдийн хооронд үл ойлголцол үүсэх	... Барилгын ажилд туслах хүчийг орон нутгийн иргэдээс бүрдүүлэхэд анхаарах ... Барилгын ажлын явцын талаар мэдээлэл түгээх	Орон нутагт	-	-	-	Бэлтгэл болон барилгын ажлын үе шатанд	Шаардлагын дагуу
				-	200.000	200.000		
2	Улсын чанартай зам дагуу зорчигчдын аюулгүй байдалд эрсдэл учрах	... Барилгын талбайн орчинд авто замаар дайран өнгөрөх зорчигчдод зориулсан анхааруулах тэмдэг тэмдэглэгээг шинэчлэх	Хужирт хархорин чиглэлийн хатуу хучилттай автозам	-	100.000	100.000	Бэлтгэл үе шатанд	Шаардлагын дагуу
3	Барилгын ажилд ашиглагдах шингэн материал болон ШТМ асгарах	... Асгаралтын үед яаралтай авах арга хэмжээний давтан сургалт явуулах ... Асгаралт үүссэн тохиолдолд яаралтай арга хэмжээ хэрэгжүүлэх	Ажилчин албан хаагчдад	-	-	100.000	Бэлтгэл болон барилгын ажлын үе шатанд	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах устгах журам
		... Асгаралтын үед ашиглах хэрэгслийг бэлдэж байршуулах	Барилгын ажлын талбайд	-		200.000		
4	Гэнэтийн болзошгүй галын аюул үүсэх	... Барилгын талбайд шатах тослох материал байршуулахгүй байх ... Ойролцоох ШТС-аас ШТМ-ын хэрэглээгээ хангах	Барилгын ажлын талбайд	-	-	-	Барилгын ажлын үе шатанд	-
5	Аюултай болон хяналттай хог хаягдал БО-нд эрсдэл үүсгэх	... Барилгын материалын сав, баглаа боодлыг ахуйн хог хаягдлаас тусад нь түр хадгалж дахин боловсруулах үйлдвэрт тушаах	Барилгын ажлын талбайд	-	-	Үйл ажиллагаа-ны зардалд	Барилгын ажлын үе шатанд	Хог хаягдлын тухай хууль “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглаалах, тээвэрлэх, дахин боловсруулах

“Тэрэлж хайпи ресорт аялал жуулчлалын цогцолбор” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2024 он

								устгах болон бүртгэх тайлагнах журам”
6	Ажилчид гэнэтийн осол аваарт өртөх	... ХАБЭА-н дадлага сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах ... Анхан шатны тусламжийн багаж хэрэгсэл, эмийн сан бэлэн байлгах	Барилгын ажлын талбайд	-	-	ХАБЭА-н үйл ажиллагааны зардал	Бэлтгэл болон барилгын ажлын үе шатанд	ХАБЭА-н тухай хуулийн холбогдох зүйл заалтууд MNS 4969:2000
7	Ажилчидын ХАБЭА-н хэвийн нөхцөл алдагдах	... ХАБЭА-н төлөвлөгөө гарган ажилчдад танилцуулан, мөрдөж ажиллах	Барилгын ажлын талбайд	-	-	ХАБЭА-н үйл ажиллагааны зардал	Бэлтгэл болон барилгын ажлын үе шатанд	ХАБЭА-н тухай хуулийн холбогдох зүйл заалтууд MNS 4969:2000
8	Цахилгааны тоног төхөөрөмжийн аюулгүй байдал алдаж, эрсдэл гарах	... Цахилгааны тоног төхөөрөмжид үзлэг хииж, гэмтлийг засварлах	Барилгын ажлын талбайд	-	-	-	Барилгын ажлын үе шатанд	Цахилгааны тоног төхөөрөмжийн аюулгүй байдал
9	Барилгын талбайд болзошгүй осол аваарын нөхцөл байдал үүсгэх	... Барилгын талбайд гэрэлтүүлэг, анхааруулах самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Барилгын ажлын талбайд	-	-	ХАБЭА-н зардал	Бэлтгэл болон барилгын ажлын үе шатанд	MNS 4643:1998
10	Галын аюулгүй байдал алдагдах	... Галын иж бүрдлийн хэвийн ажиллагаанд хяналт тавих	Барилгын ажлын талбайд	-	-	ХАБЭА-н зардал	Бэлтгэл болон барилгын ажлын үе шатанд	MNS 4999:2000 MNS 5566:2005
11	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал алдагдах	... Барилгын талбайд тээврийн хэрэгслийн хурдыг 5 км/цаг-аас хэтрүүлэхгүй байх тэмдэг тэмдэглэгээ тавих	Барилгын ажлын талбайд	-	-	ХАБЭА-н зардал	Бэлтгэл болон барилгын ажлын үе шатанд	
		Нийт зардал				600.000		

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн хог хаягдал	... Ахуйн хаягдлыг зайлуулах гэрээг орон нутгийн захиргаатай байгуулах ... Хог хаягдлын түр хадгалах шаардлагад нийцсэн хогийн сав байрлуулах ... Хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэгт богино хугацаанд зайлуулах ... Хог хаягдлыг боломжит төрлүүдээр ангилан ялгаж дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг тусад нь хадгалж дахин боловсруулах үйлдвэрт тушаах	Ажилчдын байр болон барилгын ажлын талбайд	-	-	Үйл ажиллагаа-ны зардалд	Бэлтгэл болон барилгын ажлын үе шатанд	Хог хаягдлын тухай хууль
		... Ахуйн шингэн хаягдлын цэгийн ашиглалтанд хяналт тавих		-	-	-		Сайжруулсан нүхэн жорлон MNS5924:2015
		... Барилгын ажил дууссаны дараа ахуйн хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх		-	-	200.000*		
2	Барилгын хог хаягдал	... Барилгын хог хаягдал зайлуулах гэрээг орон нутгийн захиргаатай байгуулах ... Барилгын хог хаягдлыг тусгай цэгт хуримтлуулан, боломжит төрлүүдээр нь ангилан ялгах ... Дахин боловсруулах боломжтойг тусад нь хадгалж бусдыг нь зөвшөөрөгдсөн хогийн цэгт зайлуулах ... Барилгын ажил дууссаны дараа хог хаягдлын талбайг бүрэн цэвэрлэх	Барилгын ажлын талбайд	-	-	Үйл ажиллагаа-ны зардалд	Бэлтгэл болон барилгын ажлын үе шатанд	Хог хаягдлын тухай хууль
3	Аюултай хог хаягдал	... Барилгын ажилд хэрэглэгддэг шингэн материалуудын савыг тусгай талбай буюу чингэлэгт хадгалан дахин ашиглах, боловсруулах, устгах эсвэл зөвшөөрөлтэй байгууллагад хүргэх		-	-	Үйл ажиллагаа-ны зардалд	Барилгын ажлын үе шатанд	Хог хаягдлын тухай хууль
Нийт зардал						200.000		
*- Давхар тусгагдсан зардал								

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг (төг)	Нийт зардал (төг)	Тайлбар	Баримтлах стандарт арга, ангачлал
I. Агаарын чанар								
1	SO ₂ , NO _x , тоос, тоосонцор (PM ₁₀ - PM _{2.5})	... Хяналтын фон (1 цэг) ... Барилгын ажлын талбай (2 цэг)	Жилд 1 удаа	1	60.000	180.000	Шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийлгэнэ	MNS4585:2016 MNS4048:1988 MNS5002:2000
II. Хөрс, ургамал								
2	Хөрсний хими, физик шинж чанар Хөрсний бохирдол Хөрсний элэгдэл, эвдрэл	... Хяналтын фон цэг (1 цэг) ... Барилгын ажлын талбайд (1 цэг) ... Хог хаягдлын цэгт (1цэг)	Жилд 1 удаа	1	100.000	300.000	Шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийлгэнэ	MNS3298:1991 MNS3297:1991 MNS5850:2008
3	Ургамлын зүйлийн бүрдэл, биомасс	... Барилгын талбайд	Жилд 1 удаа (7 сард)	1	500.000	500.000	Тайлан	Ургамлан нөмрөгийн
III. Усан орчин								
4	Гадаргын усны бохирдолын үзүүлэлт	... Туул гол (2 цэг)	Жилд 1 удаа	1	60.000	120.000	Шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийлгэнэ	MNS4586:1998 MNS6148:2010
5	Ундны усны эрүүл ахуйн үзүүлэлтүүд	... Ажилчдын ундны усны худаг	Жилд 1 удаа	1	60.000	60.000	Шинжилгээг магадлан итгэмжлэгдсэн лабораторид хийлгэнэ	MNS0900:2018
IV. Дуу чимээ								
6	Дуу шуугиан	Барилгын ажлын талбайд ... Тайван байгаа орчин ... Хөдөлгөөнтэй ажиллаж байгаа орчин	Жилд 1 удаа	1	25.000	50.000	-	MNS4585:2016
Зардлын дүн						1.210.000		

**АРВАН ХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ, БОМТ-ий хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны төв	Тайлагнах зардал (төг)	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	БОАЖЯ	Төлөвлөгөө тайлан хүргүүлэх	Тухайн жилийн БОМТ	Барилгын ажлын үе шатанд	-	Захирал	-
2	БЦГ	Зөвлөлдөх уулзалт	Тухайн жилийн БОМТ	Барилгын ажлын үе шатанд	-	Захирал, БО-ны асуудал хариуцсан ажигтан	Горхи-Тэрэлжийн БЦГ
3	Тухайн орчны ард иргэд	Нээлттэй өдөрлөг	Төслийн танилцуулга	Барилгын ажлын эхэнд	500.000	Компанийн удирдлагууд	Горхи-Тэрэлжийн БЦГ
	Зардлын дүн				500.000		

ХАВСРАЛТ